



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
160 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 3 дугаар сарын 16-ний өдөр № 1

Улаанбаатар хот


Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.13, 62.1.15 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.3, 7.4, 7.8.7, 7.8.7, 7.11 дэх заалтыг тус тус үндэслэн Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт Улаанбаатар хотод компанийн төв байрны хурлын зааланд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
 - 2.1 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
 - 2.2 Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай
 - 2.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай
 - 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай
 - 2.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай
 - 2.6 Орон сууц хувьчлах тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр байхаар тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудас, хоёроос доошгүй өдөр тутмын сонин, телевиз, радио болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, зарыг 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр анх нийтэд мэдээлсэн хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлын дэг, танилцах баримт бичгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталж, компанийн хувьцаа эзэмшигчдэд 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд Монголын цахилгаан холбоо ХК-ийн байранд болон цахим хэлбэрээр танилцах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаад даалгасугай.
6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдээс “Саналын хуудас”-ыг харьяалагдах брокерын компаниар нь дамжуулан хүлээн авах сүүлийн өдрийг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10:30 цаг байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар МЦХ ХК-ийн Стратеги төлөвлөлтийн газрын дарга Ч.Пүрэвсүрэнг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Удирдлага хүний нөөцийн газрын дарга Д.Болдбаатар, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа, Дотоод аудит, шинжилгээ үнэлгээний албаны дарга Ж.Азбаяр нарыг, Тооллогын комиссын даргаар Дотоод аудит, шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн Д.Ганцэцэг, гишүүдээр Удирдлага хүний нөөцийн газрын ахлах мэргэжилтэн Б.Ариунгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын хуулийн мэргэжилтэн О.Содбаяр нарыг тус тус томилсугай.
10. Шинэ төрлийн коронавирусийн халдвар Монголд Улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрүүдэд сунгаж, хувьцаа эзэмшигч компанийн хурлын зааланд биечлэн ирж хуралд оролцох боломжгүй тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зөвлөмж, чиглэл авч хувьцаа эзэмшигчдийг цахим хэрэгсэл, онлайн орчинд орчин үеийн технологийг ашиглан хуралд оролцуулах боломжийг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Д.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1.	Хурлын ирцийг бүртгэх (Зохион байгуулах комисс)	11:00-11:30
2.	Хурлын ирцийг мэдээлэх (Зохион байгуулах комисс)	5 минут
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах	70 минут
	Компанийн 2019 оны жилийн тайлан танилцуулах	
	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах	
	Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах	
	ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг танилцуулах	
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийн төслийг танилцуулах	
	Хувьчлах орон сууцны тухай танилцуулах	
5.	Асуулт хариулт, санал	20 минут
6.	Санал хураалт	5 минут
7.	Хурлын завсарлага, тооллогын комисс санал хураалтын дүнг гаргах	15 минут
8.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10.	Хурлыг хаах (Хурлын дарга)	5 минут

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2019 оны жилийн тайлан
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
3. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
4. ТУЗ-ийн Аудитын хорооны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт
5. Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөө
6. ТУЗ-ийн 2020 оны зардлын төсвийн төсөл
7. Хувьчлах орон сууцны мэдээлэл
8. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр
9. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн мэдээлэл

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Брокер дилерийн компани/

Брокерийн овог нэр

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт компанийн төв байрны хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан тохиолдолд өгөх санал
1.	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			
2.	Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай: 1.1. Нийт хөрөнгийг ... төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг ... төгрөгөөр; 1.2. Өр төлбөрийн нийт дүнг ... төгрөгөөр; 1.3. Эзэмшигчийн өмчийг ... төгрөгөөр тус тус баталсугай. 2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.			
3.	ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг баталсугай.			
4.	ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг Хавсралтаар баталсугай. 2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.			
5.	Орон сууц хувьчлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах 30 квадрат метр талбай бүхий орон сууцыг Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Төвийн бүсийн холбооны газрын инженер Ц.Нанжид, Нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах 30 квадрат метр талбай бүхий орон сууцыг Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Технологийн газрын			

№	Хэлэлцэх асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан тохиолдолд өгөх санал
		ахлах инженер М.Баярсайхан, Өмнөговь аймгийн Даланзадгад сумд байрлах 63 квадрат метр талбай бүхий орон сууцыг Өмнөговь аймгийн Холбооны газрын Техник үйлчилгээний ахлах мэргэжилтэн Ц.Дэлгэрмаа нарт тус тус үлдэгдэл өртгөөр нь хувьчлан олгосугай. 2. Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах 30 квадрат метр орон сууцны үлдэгдэл өртгийг төлөхийг Ц.Нанжидад, Нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах 30 квадрат метр орон сууцны үлдэгдэл өртгийг төлөхийг М.Баярсайханд, Өмнөговь аймгийн Даланзадгад сумд байрлах 63 квадрат метр орон сууцны үлдэгдэл өртгийг төлөхийг Ц.Дэлгэрмаад тус тус даалгасугай. 3. Орон сууц хувьчлах, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх, компанийн үндсэн хөрөнгөөс хасах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Алтан-Очир/-д даалгасугай.			

Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

2020 оны сарын өдөр

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Брокер дилерийн компани/

Брокерийн овог нэр

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт компанийн төв байрны хурлын танхимд болно.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
	Ердийн гишүүд	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
	Хараат бус гишүүд	
1		
2		
3		
4		
5		

Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

2020 оны сарын өдөр

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. **Жишээ нь:** та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн компани дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг утсаар лавлаж болно.
4. Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

.....
.....
.....
.....
.....